

**Монгол Улс, ХБНГУ-ын улс төр,  
эдийн засгийн харилцаа  
(1990 оноос өнөөг хүртэл)**

*ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн  
эрдэм шинжилгээний ажилтан Ц.Лхам (М.А)*

Монгол Улс, ХБНГУ-ын хооронд 1974 онд дипломат харилцаа тогтсоноос хойш 1986 он хүртэл буюу өөрөөр хэлбэл хүйтэн дайны үед тус хоёр улсын харилцаа тун хязгаарлагдмал байсан билээ. Харин 1990 оноос хоёр талын харилцаа илтэд идэвхжихэд нөлөөлсөн хэд хэдэн хүчин зүйлсийг дурдъя.

Нэгдүгээрт, 1980-аад оны сүүлч үеэс Монголын гадаад бодлогын чиг баримтлал өөрчлөгдсөн; хоёрдугаарт, 1990-1994 онд Монголд нүүрлэсэн эдийн засгийн их хямрал; гуравдугаарт, Монгол Улс, БНАГУ-тай бүх талын, сайн харилцаатай байсан; дөрөвдүгээрт, 1990 онд Монгол Улс нь Германы хөгжлийн тусламжийг хүртэх эрхтэй орны тоонд багтах болсон зэрэг болно. Одоо энэ хүчин зүйлсийг дэлгэрүүлэн тайлбарлая.

1970-аад оны дунд үеэс ЗХУ болон хуучин социалист орнуудад эдийн засгийн хямрал алгуурхан эхэлсэн явдал хожим 1990-ээд оны эхэн үед Монгол Улс, ХБНГУ-ын харилцаа идэвхжин хөгжих урьдчилсан нөхцөл болсон гэж үзэж болох юм. Учир нь улам бүр гүнзгийрч байсан эдийн засгийн хямралын улмаас М.Горбачев 1985 онд алдарт "перестройка"-г эхлүүлсэн билээ. Энэхүү "перестройка" нь намжмал байдлыг авчирч, эцсийн эцэст хүйтэн дайныг төгсгөвөр болгоход хүргэсэн гэдгийг бид бүгд мэдэх билээ. ЗХУ-ын нөлөөгөөр 1986 онд БНМАУ-д ч мөн өөрчлөлт шинэчлэлтийн салхи сэвэлзэж, эрх баригч МАХН-ын XIX Их хурлын (1986.05.28-31) шийдвэрийн<sup>1</sup> үндсэн дээр өөрийн орны эрх ашигт нийцүүлэн капиталист орнуудтай идэвхтэй хамтран ажиллахыг чармайх болсон юм. Энэ нь нэг талаас өөрийн улсын эдийн засгийн хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх, нөгөө талаас Зөвлөлтийн цэрэг Монголын нутаг дэвсгэрээс бүрмөсөн гарах болсонтой<sup>2</sup> холбогдуулж аюулгүй байдлаа улс төрийн аргаар хангах гэсэн чармайлт байв. Монголын гадаад бодлогын чиг баримтлал ийнхүү өөрчлөгдсөн нь МУ, ХБНГУ-ын харилцааг тогтонги байдлаас гаргахад нөлөөлсөн анхны хүчин

зүйл болсон болов уу. Ийнхүү 1986 онд МУ, ХБНГУ-ын хооронд Соёлын хэлэлцээр, 1988 онд Соёлын хэлэлцээрийн протокол тус тус байгуулагдаж, хоёр талын улс төрийн харилцааны эхлэл тавигдсан ч харахан бүрэн идэвхжээгүй байв. Харин хоёр талын харилцаа идэвхжихэд хүргэсэн дараагийн нэг хүчин зүйл бол 1990-1994 онд Монголд нүүрлэсэн эдийн засгийн их хямрал юм. Монголын тухайн үеийн эдийн засгийн байдлыг тоогоор илэрхийлбэл:

Үзүүлэлтийн нэр	1989	1990	1991	1992	1993	1994
Эдийн засгийн өсөлт (%)	4,2	-2,5	-9,2	-9,5	-3	2,3
Аж үйлдвэрийн салбарын эдийн засгийн өсөлт		-0,3	-13,1	-11,5	-10,6	-2,7
Хөдөө аж ахуйн салбарын эдийн засгийн өсөлт		-2	-5,1	-4	-7,1	7,1
Инфляц (%)	-	-	152,4	325,5	183	66,3
Гадаад худалдааны тэнцэл (Mio \$)	1684,5	363,3	-12,9	-29,9	3,6	97,7
Экспорт (Mio US \$)	721,5	660,7	348	388,4	382,6	356,1
Импорт (Mio US \$)	963,0	924	360,9	418,3	349	258,4
Гадаадын тусламж (Mio US \$)			313,7	236,8	234,4	167,4
Валютын нөөц (Mio US\$)			49,3	20,5	4,6	27,2

Эх сурвалж: Үнэн сонин, 16-19.08.1997 №60 (18635), 2-р тал; 11-12.02.1999 №17, 7-р тал

Эдийн засгийн ийм хүнд нөхцөлд Монгол Улс нь эдийн засгийн хувьд дэлхийд тэргүүлэх улсын нэг болохынх нь хувьд ХБНГУ-тай илүү нягт хамтран ажиллах тун их сонирхолтой байсан болов уу. Дараагийн хүчин зүйлс нь ХБНГУ-ын зүгээс явуулсан бодлоготой холбоотой юм. ХБНГУ нь хуучин БНАГУ-ыг өвлөгч улс болохын хувьд БНАГУ-аас БНМАУ-тай хөгжүүлж ирсэн харилцаа, хамтын ажиллагааны төвшинг бууруулахгүй байх бодлогыг хоёр Герман нэгдсэнээс хойшх анхны жилүүдэд Монгол Улсын тухайд ХБНГУ нь баримталж байсан нь ажиглагддаг.<sup>3</sup> Гэтэл БНМАУ нь БНАГУ-тай улс төр, эдийн засаг, нийгмийн бараг бүхий л хүрээнд сайн харилцаатай байсан<sup>4</sup> тул Монгол Улс, ХБНГУ-ын харилцаа ч мөн энэ үеэс

төвшин дээшлэх шаардлагатай тулгарсан болов уу. Энэ нь дээр дурдсанчлан гуравдах хүчин зүйл болсон юм. 1990 онд ЭЗХАХБ-аас Монгол Улсыг хөгжиж буй орон хэмээн хүлээн зөвшөөрснөөр<sup>5</sup> Монгол Улс ХБНГУ-тай хөгжлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх боломжтой болсон нь хоёр талын хамтын ажиллагаа эрчимтэй хөгжих дөрөвдэх хүчин зүйл болсон гэж үзэж байна.

МУ, ХБНГУ-ын улс төр, эдийн засгийн хамтын ажиллагааны энэхүү 16 жилийн түүхийг дүгнэхэд хоёр талын харилцаанд гарсан үндсэн өөрчлөлтийг харуулсан 3 үе шат тодорч байна.

### Нэгдүгээр үе шат (1991-1992)

Энэ үед Монголд эдийн засгийн их хямрал нүүрлэсний зэрэгцээ ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих үйл явц ид өрнөж байсан тул Монгол-Германы харилцаа ч мөн энэ хүнд үеийг даван туулахад чиглэж байжээ. Өөрөөр хэлбэл энэ үед хөгжлийн хамтын ажиллагаа чухал байр суурийг эзэлж байв. Мөн энэ үед хоёр тал бодит нөхцөл байдал, байр сууриа харилцан ойлголцож, хамтын ажиллагааны цаашдын чиглэлийг тогтоох боломж бүрдсэн билээ.

Улс төрийн харилцаа: 1990 онд тус хоёр улс Улаанбаатар, Бонн хотуудад харилцан Элчин сайдын яамаа нээн ажиллуулсан. Энэ үед ХБНГУ-ын зүгээс Монгол Улсад сайдын төвшинд<sup>6</sup>, харин Монгол Улсаас ХБНГУ-д Ерөнхий сайдын төвшинд<sup>7</sup> тус тус албан ёсны өндөр дээд хэмжээний айлчлалыг хийсэн бөгөөд энэ нь харилцан байр сууриа ойлголцох, хамтран ажиллах боломжийг хайхад чиглэж байв. Үүнд ялангуяа Холбооны эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн сайд К.Д.Шпрангерын айлчлал тухайн үед Монголын нөхцөл байдлыг ойлгоход чухал үүрэг гүйцэтгэсэн<sup>8</sup> гэдгийг онцлон тэмдэглэмээр байна.

Хөгжлийн хамтын ажиллагаа: 1990 оны 11-р сарын Монгол Улсын Ерөнхий сайд Д.Бямбасүрэн Холбооны Канцлер Х.Коль-д захидал илгээж, санхүүгийн тусламж үзүүлэхийг хүссэний<sup>9</sup> үр дүнд хоёр талын хөгжлийн хамтын ажиллагаа эхлэлээ тавьж, 1991 онд Улаанбаатар хотноо хоёр талын хөгжлийн хамтын ажиллагааны талаар Засгийн газар хоорондын хэлэлцээ явагдаж, 1992 онд

Техникийн хамтын ажиллагааны тухай Монгол Улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулагдсан билээ.

	1991-1992 он
Төслийн санхүүжилт	1991, 1992 онуудад жилд дунджаар 19,5 сая ДМ-ийн хөгжлийн тусламж үзүүлсэн.
Төслийн сонголт	1991-1992 онд хоёр талын хөгжлийн хамтын ажиллагаа Монголд хурцаар тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд илүү чиглэгдэж байсан гэж хэлж болохоор байна. Тухайлбал 1991 онд үзүүлсэн нийт хөгжлийн тусламжийн (24 сая ДМ) дөрөвний нэгийг Улаанбаатар хотын хүнсний өдөр тутмын хангамжийг тасалдуулахгүйн тулд эдийн засгийн үр ашиг муутай төслүүдэд <sup>10</sup> зарцуулсан байна. Гэвч энэ нь нэг талаар Монголд хуучин БНАГУ-ын үеэс уламжлагдсан "хөгжлийн тусламжийн балгас" үлдээхгүй байх нь зүйтэй гэсэн Германы бодлоготой <sup>11</sup> холбоотой юм. 1991-1992 онд хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжсэн төслүүд ерөнхийдөө стратегийн ач холбогдол бүхий үйлдвэрлэлийн салбаруудыг <sup>12</sup> хамарч байв.
Төслийн төлөвлөлт	1991-1992 онд хэрэгжүүлсэн төслүүд нарийвчилсан төлөвлөгөөгүй, ихэвчлэн барааны тусламж хэлбэрээр хэрэгжиж байв. Энэ үед хэрэгжсэн „Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төсөл“-ийг дараагийн үе шат буюу 1993-2005 онд хэрэгжүүлсэн „Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төсөл“-тэй харьцуулж үзвэл том ялгаатай байна. Хэдийгээр эдгээр төсөл нь Монголын Жижиг, дунд үйлдвэрүүдэд зээл олгосноороо хоорондоо ижил боловч хоёрдахь үе шатанд хэрэгжсэн төсөл нь эрсдэлийг бууруулах арга хэмжээг хослуулснаараа илүү үр дүнтэй байсан билээ. Гэвч эхний үе шатанд ганц нэг сайн төлөвлөсөн төсөл байсныг дурдахгүй өнгөрч болохгүй.

Эдийн засгийн хамтын ажиллагаа: 1991-1992 онд хоёр тал жилд дунджаар 26,3 сая ДМ-ийн худалдаа хийсэн бөгөөд үүнээс Монголын талын хүлээсэн гадаад худалдааны алдагдал жилд дунджаар 400%-д хүрч байв. Энэ үед ХБНГУ-аас Монгол Улсад 100.000 ам.долларын шууд хөрөнгө оруулалт хийсэн байна. Үүнээс үзэхэд эхний энэ үе шатанд хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалт тун

бага төвшинд байжээ. Монгол Улс, ХБНГУ-ын хоорондын хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхүүлэн дэмжих тухай гэрээнд хэдийгээр хоёр тал 1991 онд гарын үсэг зурсан боловч 1996 онд л энэ нь хүчин төгөлдөр болсон тул Монголд хийсэн Германы хөрөнгө оруулалт үндсэндээ 1996 он хүртэл эрх зүйн хамгаалалтгүй байсан гэсэн үг юм. Харин Германы тал энэ үед хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлэхийн тулд зарим тодорхой арга хэмжээг санаачлан зохион байгуулж байжээ. Жишээлбэл Монголын үйлдвэрлэгчид Европын болон Германы зах зээлд бүтээгдэхүүнээ гаргах боломжийн талаар худалдааны семинарыг 1991 онд, Монголын экспортыг дэмжих уулзалтыг 1992 онд тус тус Германы тал санаачлан зохиож байжээ.

### **Хоёрдугаар үе шат (1993-2005)**

1993 оноос хоёр тал батлан хамгаалах салбарт хамтран ажиллах болсон нь хоёр талын харилцаанд шинэ үе шат эхэлснийг тодорхой хэмжээгээр илтгэх болсон. Үүнийг судалж үзэхэд Төв Азийн бүс нутагт тогтвортой байдлыг хангах асуудал энэ үеэс Монгол Улс болон ХБНГУ-ын аль алиных нь сонирхлыг татах болж, энэ нь улмаар Монголын ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих үйл явц, ялангуяа батлан хамгаалахын салбар дахь ардчиллыг дэмжих замаар Төв Азийн бүс нутгийн тогтвортой байдлыг хангахад тодорхой хэмжээгээр хувь нэмрээ оруулж болох юм гэсэн бодлогыг ХБНГУ баримтлахад хүргэсэн болов уу гэсэн дүгнэлтэд хүрч байна. Ийнхүү энэ үе шатанд хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа нь хөгжлийн хамтын ажиллагаанаас улс төр, батлан хамгаалахын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд шилжин төвлөрөх болжээ. Одоо үүнийг дэлгэрүүлэн тайлбарлая.

Төв Ази дахь Германы буюу Европын сонирхол нь эдийн засгийн болон аюулгүй байдлын гэсэн хоёр талтай юм.

**Нэгдүгээрт**, эдийн засгийн сонирхол: ЗХУ задран унасны дараа Төв Ази болон Каспийн тэнгисийн орчимд шинээр тусгаар тогтносон улсууд бий болсон бөгөөд тэд эрчим хүчний баялаг нөөцөөрөө дэлхий нийтийн анхааралд өртөж, их гүрнүүдийн "New Great Game" кэмээн нэрлэгдсэн өрсөлдөөн эхэлсэн билээ. Энэ үед Европын

Холбоо Каспий орчмын нутгийг "бүх Европын сонирхол"-ын бүс хэмээн зарласныг<sup>13</sup> 1990 оны Европын Холбооны Парисын хартаас үзэж болно. Мөн 1992 онд Германы Батлан хамгаалах яамнаас гаргасан батлан хамгаалах бодлогын чиг баримтлалд "Германы бодлого нь дэлхийн эдийн засгийн шударга журмын үндсэн дээр дэлхий нийтийн худалдааг хамгаалах, түүхий эд болон дэлхийн зах зээлд саадгүй хүрэх олон талт сонирхлыг хэрэгжүүлэхийг удирдлага болгоно"<sup>14</sup> хэмээн заасан байдаг. Үүнээс үзэхэд Төв Азийн эрчим хүчний нөөц баялаг бүхий 52 сая хэрэглэгчтэй зах зээлд нэвтрэх бодлогыг ХБНГУ тухайн үед баримтлах үндэслэлтэй байжээ.

**Хоёрдугаарт**, аюулгүй байдлын сонирхол: Үүнд эн тэргүүнд тус бүс нутгаас Европт чиглэсэн миграц, мансууруулах бодисын худалдаа орж байна. Мөн үүнээс гадна Төв Ази нь тухайн үед дэлхийн хамгийн халуун цэгүүдийн нэг байсан бөгөөд 1992 онд Тажикстанд тайван жагсаал хоёрхон сарын дотор зэвсэгт мөргөлдөөн, эцэст нь иргэний дайн болж 5 жилийн туршид үргэлжилсэн билээ. Ер нь Төв Азийн бараг улс бүхэнд ил, далд янз бүрийн хямралын аюул нуугдаж байсан бөгөөд хэрэв ийм хямралын аюул даамжирч, мөргөлдөөн үүсээд, түүнд ОХУ болон бусад гуравдагч орнууд хутгалдан орсон тохиолдолд Европын аюулгүй байдал шууд хөндөгдөх ажээ. Ийм болгоомжлол бодитоор оршиж буйг Европын Холбооны 1995 оны 10-р сарын 10-нд гаргасан албан ёсны мэдэгдэл<sup>15</sup> нотолж байна.

Герман ба Европын Холбоо нь Төв Азид хэдий эдийн засгийн сонирхолтой байх боловч тухайн бүс нутагт тогтвортой байдал бий болоогүй нөхцөлд эдийн засгийн сонирхлоо биелүүлэх таатай нөхцөл бүрдэж чадахгүй тул Герман ба Европын Холбооны хувьд Төв Азийн бүс нутгийн тогтвортой байдал асуудлын зангилаа нь болж байв.

Монгол Улсын хувьд Төв Азийн тогтвортой байдал түүний аюулгүй байдалд нөлөөтэйгээс гадна тухайн бүс нутгийн нэг хэсэг болох Монгол Улсын тогтвортой байдал ч бүс нутагтаа зохих хэмжээний нөлөө үзүүлж чадах байв. Тухайн үед Монгол Улс нь ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжихдээ ардчиллын үлгэр жишээ болж, улс төрийн тогтвортой байдлаа хадгалснаар бүс нутагтаа тогтвортой байдлын нэг хүчин зүйл болж байв.

- идэвхтэй гадаад бодлогынхоо үр дүнд бүс нутагтаа аюулгүй байдал, тогтвортой байдал, итгэлцлийг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулж байв. Тухайлбал 1992 онд Монгол Улс нь нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс хэмээн зарлаж,<sup>16</sup> үүнийг цаашид цөмийн зэвсэгтэй их таван гүрнээр хүлээн зөвшөөрүүлж, баталгаа гаргуулж чадсан байна. 1989 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 44-р дүгээр чуулган дээр Монгол Улсын Гадаад харилцааны сайд Г.Гомбосүрэн Зүүн хойд Азийн улс орнуудыг байнгын уулзалтын механизм бий болгоход хүчин чармайлт гаргахыг уриалсан байна.<sup>17</sup>
- Монгол Улс нь Төв Ази төдийгүй Зүүн Хойд Азийн бүс нутгийн аль ч улстай найрсаг харилцаатай, ямар нэгэн газар нутгийн маргаан, томоохон зөрчилгүй цорын ганц улс болохын хувьд цаашид бүс нутагтаа хамтын ажиллагааг хөгжүүлэх зуучлагчийн үүрэг гүйцэтгэхэд нэн тохиромжтой байв.

Цаашлаад энэхүү үе шатанд Монгол Улсад айлчилсан Германы томоохон зочид, төлөөлөгчдийн хэлсэн үгэнд

- “Монгол Улс нь умард, өмнөд их хөршүүд болон Төв Азийн шинэ орнуудтай яриа хэлцээний идэвхтэй бодлого явуулах замаар түншийн тогтвортой харилцаа тогтоож, урьдын хурцадмал байдлыг шинэ итгэлцлэлээр солихыг эрмэлзэж буйг бид сэтгэл нэн ханамжтай ажиглан харж байдаг” (Холбооны Ерөнхийлөгч Р.Херцог),<sup>18</sup>
- “Монголын ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үйл явцад оруулж буй Германы хувь нэмрийг бид зөвхөн Монголын хөгжилд төдийгүй, бүс нутгийнх нь хөгжилд оруулж буй бидний хувь нэмэр гэж ойлгодог” (Холбооны Батлан хамгаалахын сайд Р.Шарпинг),
- Германы тал Монгол Улс 10 жилийн богино хугацаанд ардчиллын замаар замнахдаа их амжилтанд хүрч, бүс нутгийн орнууддаа үлгэр жишээ болохын сацуу бүс нутагтаа тогтвортой байдлын нэг хүчин зүйл болж буйг, түүнчлэн Зүүн Хойд Азийн бүс нутгийн интеграцийн үйл явцад идэвхтэй оролцож буйг сайшаан тэмдэглэсэн<sup>19</sup> зэрэгт анализ хийж үзэхэд Германы тал Монгол Улс хэдийгээр жижиг буурай улс боловч Төв Азийн тогтвортой байдлыг хангахад хувь нэмрээ оруулж чадах бөгөөд түүний энэхүү хувь нэмрийг

дэмжих замаар Төв Азийн бүс нутгийн тогтвортой байдлыг хангахад ХБНГУ өөрийн хувь нэмрийг тодорхой хэмжээгээр оруулж болох юм гэсэн бодлогыг баримталсан болов уу гэсэн дүгнэлтэнд хүрч байна.

Улс төрийн харилцаа: Эл хугацаанд Монголын Ерөнхийлөгч 2 удаа, УИХ-ын дарга 3 удаа, Гадаад хэргийн сайд 2 удаа ХБНГУ-д, Холбооны Ерөнхийлөгч 1 удаа, Холбооны Бундестагийн дэд Ерөнхийлөгч 4 удаа, Холбооны Гадаад хэргийн сайд 1 удаа Монголд тус тус харилцан айлчилсан бөгөөд үүнд хоёр талын дээд хэмжээний айлчлалын төвшин нь дээшилж, давтамж нь ч нэмэгдсэн байна.

Мөн энэ үед хоёр тал гадаад бодлогын үзэл баримтлалаа боловсруулсан бөгөөд Монголын Гадаад бодлогын үзэл баримтлал (1994 он)-д Монгол Улс нь ХБНГУ-ыг хоёр хөрш орны дараа орохуйц, АНУ, Японтой дүйцэхүйц гадаад бодлогын тэргүүлэх хоёрдахь чиглэлийн орон буюу Европ дахь гол түншээ гэж үзсэн байна.<sup>20</sup> Харин Холбооны Засгийн газрын Азийн концепц (1993 он)-д ч тэр, Германы Азид чиглэсэн бодлогын 10 удирдамж (1994 он)-д ч тэр Монгол Улс гэсэн үг нэг ч таарахгүй бөгөөд Монголтой холбоотой байж болох 2 өгүүлбэр бий. Үүнд "Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжиж буй орнуудын хувьд эдийн засаг, нийгмийн бодлогод зөвлөмж өгөх тухай асуудал яригдах бөгөөд бид үүнд хувийн аж ахуйн нэгжийг үүсгэн байгуулахад туслах болно"<sup>21</sup> гэсэн заалт бий боловч энэ нь Монгол Улсын хувьд хоёр талын хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд 1991 оноос хэдийнээ хэрэгжиж эхэлсэн байв. 2002 онд гаргасан Холбооны Засгийн газраас Зүүн азийн талаар баримтлах журамд "Орос, Хятадын дунд геополитикийн сэндвич байрлалтай ардчилсан Монгол Улсыг бие даасан гадаад бодлого явуулахад нь бид дэмжлэг үзүүлнэ. Ардчилсан Монгол улсад цаазаар авах ялыг үгүй болгохын тулд бид цаашид чармайх болно. Герман-Монголын худалдааг дэмжих нь зүйтэй боловч үүнийг хөгжүүлэх боломж тун хязгаарлагдмал юм. Газар тариалан-нүүдлийн аж ахуйтай тус оронд амьдралын үндэс суурь болсон экологийн тэнцвэртэй байдлыг хамгаалахад Монгол Улстай хамтран ажиллах болно."<sup>22</sup> гэсэн заалт бий. Эдгээр үзэл баримтлал нь хоёр улс тус тусын гадаад бодлогыг системчлэн тодорхойлоход ач холбогдолтой байсан хэдий ч хоёр талын харилцаа, хамтын ажиллагаанд эргэлт гаргахуйц шинэлэг зүйл тусгагдаагүй мэт.

Энэхүү үе шатанд хоёр талын харилцааг баяжуулсан нэг зүйл нь 1993 онд Монголд анхны парламент сонгогдсоноос хойш хоёр улсын парламент хоорондын хамтын ажиллагааг эхэлж, төлөөлөгчид солилцохоос гадна сургалтанд хамруулах, ном, мэдээлэл солилцох зэргээр өргөжсөн явдал юм. Мөн Монголын талын санаачилснаар 1995 онд "Монгол Улс, ХБНГУ-ын харилцааны үндсийн тухай тунхаглал"-ыг байгуулсан ажээ.

Батлан хамгаалахын хамтын ажиллагаа: 1993 онд хоёр тал батлан хамгаалахын салбарт албан ёсны харилцаа тогтоосон бөгөөд энэ салбар дахь хоёр талын хамтын ажиллагаа нь доорх эрх зүйн баримт бичгийн үндсэн дээр хөгжиж байна. Үүнд:

**Нэгдүгээрт**, "Батлан хамгаалах яамдын хамтын ажиллагааны тухай хамтарсан мэдэгдэл" (1995). Уг мэдэгдэлд хоёр орны батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа нь "олон улсын аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх"<sup>23</sup>-д чиглэх тухай заажээ. Бусад зорилго нь Монголын зэвсэгт хүчинд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн байна.

**Хоёрдугаарт**, "Монголын цэргийн боловсон хүчнийг Германы цэргийн сургуульд сургах тухай Монгол Улсын Батлан хамгаалах яам, Холбооны Батлан хамгаалах яамд хоорондын хэлэлцээ" (1995). 1992 оноос хойш өнөөг хүртэл нийт 86 Монголын офицер, цэргийн мэргэжилтнүүдийг Германд сургасан байна.

ХБНГУ 1994 онд цэргийн атташегаа анхлан томилсны зэрэгцээ 1995 онд Холбооны Батлан хамгаалах яамны төрийн нарийн бичгийн дарга Б.Вильц Монгол Улсад айлчилснаар албан ёсны дээд хэмжээний харилцан айлчлалын эхлэлийг тавьсан байна.

Хоёр талын батлан хамгаалахын хамтын ажиллагааны оргил үе 2002 онд Монголын Батлан хамгаалахын сайд Р.Гүррагчаа ХБНГУ-д айлчлах үед тохиож, хамтын ажиллагааны цар хүрээ өргөжсөн байна. Урьд нь Жанжин Штабын хооронд зөвлөлдөх уулзалт хийх, цэргийн офицер бэлтгэх, цэргийн хүмүүнлэгийн тусламж үзүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байсан бол 2002 оноос цэргийн ахлагч, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны ажиглагч бэлтгэх, тодорхой сэдэвт сургалт семинар тогтмол зохион байгуулах, цэргийн холбоо, цэргийн эмнэлэгт хүмүүнлэгийн тусламж үзүүлэх зэргээр улам

өргөжин гүнзгийрсэн байна.

Хөгжлийн хамтын ажиллагаа: Германы хөгжлийн бодлого өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 2002 оноос Монгол-Германы хөгжлийн хамтын ажиллагаанд ч мөн өөрчлөлт орсон тул хоёр талын хөгжлийн хамтын ажиллагааг хоёр үе (2001 оноос өмнөх ба хойших үе) болгон хуваасан билээ.

2001 оны 3 дугаар сард хоёр тал хамтран Монголд хэрэгжсэн төслүүдэд шалгалт хийсний үндсэн дээр Монгол-Германы Засгийн газар хоорондын хөгжлийн хамтын ажиллагааны 2002/2003 оны хэлэлцээгээр хоёр орны цаашдын хөгжлийн хамтын ажиллагааг

- эдийн засгийн шинэчлэл, зах зээлийн эдийн засгийн хөгжил
- байгаль орчны бодлого, байгалийн нөөцийн хамгаалалт (сэргээгдэх эрчим хүчийг оролцуулан)

гэсэн хоёр үндсэн чиглэлд төвлөрүүлэхээр болжээ. Германы хөгжлийн хамтын ажиллагааны шинэ журмын дагуу Монгол шиг жижиг улс хөгжлийн хамтын ажиллагааны үндсэн ганц чиглэлтэй байх ёстой авч Германы тал Монголын нөхцөл байдлыг харгалзан хоёр үндсэн чиглэлтэй байхыг зөвшөөрсөн нь түүний дэмжлэг тусламжийн нэг илрэл гэлтэй.

Одоо энэ хоёр үеийг хооронд нь харьцуулъя.

	Нэгдүгээр үе, 1993-2001	Хоёрдугаар үе, 2002-2005
Төслийн санхүүжилт:	1993-2001 онд жил дунджаар 29 сая ДМ-ийн хөгжлийн тусламж үзүүлсэн нь өмнөх үеийнхээс даруй 32,7%-иар өссөн байна.	2002-2005 онд жил дунджаар 11,25 сая еврогийн хөгжлийн тусламж үзүүлсэн нь өмнөх үеийнхээс 22,4%-иар буурчээ.
Төслийн сонголт:	Энэ үед хэрэгжүүлсэн төслүүд бараг бүх салбарыг хамарч байв. Жишээлбэл эдийн засаг, хүрээлэн буй орчин, эрчим хүч, харилцаа холбоо, боловсрол, нийгэм, эрүүл мэнд г.м	Энэ үед бүх төслүүд зөвхөн дээр дурдсан хоёр үндсэн чиглэлд төвлөрч байна.

<p>Төслийн төлөвлөлт:</p>	<p>Энэ үе шатанд төсөл тус бүрийн хувьд авч үзэхэд төлөвлөлт сайжирсан байна. Техникийн хамтын ажиллагааны төслүүдэд асуудлыг 3 төвшинд (бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, зорилтот бүлэг) шийдвэрлэх бүтэц бий болсон нь ажиглагдаж байна. Харин санхүүгийн хамтын ажиллагааны төслүүдийн хувьд хөнгөлөлттэй зээлийг олгохдоо шаардагдах үйлчилгээг хавсран үзүүлэх болсон бөгөөд үүнийг ихэвчлэн нэмэлт болон дагалдах арга хэмжээний хэлбэрээр хэрэгжүүлсэн байна.</p>	<p>2002 оноос төслүүдийг хооронд нь уялдаатайгаар төлөвлөх болсноор төслүүдийн багц бий болж байна. Жишээлбэл бүсийн тулгуур төвүүд болох Дархан-Уул, Улиастайд ажил эрхлэлт, орлого олох боломжийг нэмэгдүүлэх зорилгыг бие даасан 4 төсөл хамтран хэрэгжүүлж байна.</p>
---------------------------	--	---

Эдийн засгийн хамтын ажиллагаа: 1993-2004 онд хоёр талын судалдааны эргэлт жилд дунджаар 39,7 сая еврод хүрсэн нь 1991-1992 оны үеийг бодвол бараг 2 дахин нэмэгдсэн боловч л худалдаанаас Монголын талын хүлээсэн гадаад худалдааны алдагдал 700%-д хүрсэн байна.

Хэрэв 1990, 2001 онуудад хийсэн хоёр талын худалдааг (арьцуулан үзвэл Монголын экспорт 7 дахин, импорт 19,1 хувь буурчээ. Манай улсаас ХБНГУ-д экспортолдог барааны 60 гаруй зүйлг өлөн гэдэс, самнасан ноолуур, ноолууран сүлжмэл, импортлодог барааны дийлэнхийг хүнсний зүйл, пиво, дарс, машин, онг төхөөрөмж, ачааны болон хөнгөн тэрэг, мебель зэрэг бараа илэлж байна.<sup>24</sup>

2003 оны 12 сарын 31-ний байдлаар Монгол Улсад ХБНГУ-ын цагнасан болон хамтарсан 91 компани нийт 5.89 сая ам. долларын өрөнгө оруулалт хийсэн байна. Германы хөрөнгө оруулалтыг албараар авч үзвэл хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл (29%), худалдаа, нийтийн хоол (23%), барилга, барилгын материалын үйлдвэрлэл (15%), мал аж ахуй, түүхий эд боловсруулалт (11%),

аялал жуулчлалын салбарт (4%) хөрөнгө оруулалт түлхүү орсон байна.<sup>25</sup>

1993-2005 онд хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэхийн тулд төрөл бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Үүнд:

- Эдийн засгийн өдөрлөг, хөрөнгө оруулалтын семинар, эдийн засгийн форум, уулзалт зэрэг худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих мэдээлэл сурталчилгааны арга хэмжээг 1996 оноос хойш жил тутам хоёр тал ээлжлэн зохион байгуулж байв.
- Эл хугацаанд хоёр талын хамтын ажиллагаанд бэрхшээл учруулахгүйн тулд Монголын талаас багагүй хүчин чармайлт гаргасны дүнд өрийн асуудлуудыг 1995, 2002 онуудад шийдвэрлэж чадсан.
- 2002 онд Монгол Улсын Ерөнхий сайдын айлчлалын үеэр ХБНГУ-ын зүгээс Монголын талд Хермесийн баталгаа олгох болсны зэрэгцээ, ЭЗХАХБ-д Монголын зэрэглэлийг ахиулах талаар өөрийн санаачилгаар хөөцөлдөн ажиллахаар болжээ.

Монгол-Германы эдийн засгийн хамтын ажиллагааны үндсэн нөхцөл, худалдааны эрх зүйн үндэслэлийг Монгол Улс, Европын Холбооны хоёр талын гэрээ, хэлэлцээрийн үндсэн дээр бий болгодог (үүнийг Монгол Улс 1996 он хүртэл бүрдүүлж чадсан) тул Монгол-Германы эдийн засгийн хамтын ажиллагааг Монгол Улс-Европын Холбоо-ХБНГУ гэсэн гурвалсан хүрээнд цаашид нарийвчлан судалбал үр өгөөжтэй байх болов уу.

### **Гуравдугаар үе шат (2006 оноос хойш)**

2006 оны 4 дүгээр сарын 3-4-ний өдрүүдэд Монгол Улс, ХБНГУ-ын Гадаад хэргийн яамд хоорондын зөвлөлдөх уулзалт болж, үүнд Монгол-Германы харилцаа бүхий л салбарт эрчимтэй хөгжиж буйг үндэслэн хоёр талын хооронд иж бүрэн түншлэлийн харилцаа тогтсон гэж үзсэний зэрэгцээ Германы тал Монгол Улсын гуравдахь хөршийн бодлогыг сонирхон, Монгол Улстай гуравдахь хөршийн хэмжээнд харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлэхэд бэлэн байгаагаа мэдэгдсэн байна.<sup>26</sup> Германы талын энэхүү байр суурь

нь хоёр орны харилцааны түвшин дээшилж, хамтын ажиллагааны нэгэн шинэ үе эхэлж буйг илтгэж байна. Энэ үе шатанд Монгол-Германы хамтын ажиллагаа уул уурхайн салбарт хэдийнээ өрнөж эхэлжээ. Германчууд “Багануур” уурхайн хүрэн нүүрснээс шатдаг хий гаргах авах технологийг Монголд нэвтрүүлж,<sup>27</sup> Тавантолгойн нүүрсний ордод Германы алдарт “Сийменс” компаниар ахлуулсан олон улсын консорциум<sup>28</sup> ирж ажиллах цаг ойртож буй бололтой.

## Ишлэл, зүүлт

- <sup>1</sup> XIX. Parteitag der Mongolischen Revolutionären Volkspartei – Materialien, Berlin 1987, S.19
- <sup>2</sup> Зөвлөлт, Хятадын хамтарсан албан мэдээ, Үнэн сонин, 1989.05.20, №120(17337), 6 дугаар тал
- <sup>3</sup> БНМАУ-ын Гадаад харилцааны төв архив, Ф№70, Х/Н№38, БНМАУ, ХБНГУ-ын улс төрийн харилцаа (1990-И/14-нөөс 1991-И/11)
- <sup>4</sup> Д.Уламбаяр, Монгол, Өрнөдийн орнуудын харилцаа эрт, эдүгээ, УБ, 2004, 183-196 дугаар тал
- <sup>5</sup> БНМАУ-ын Гадаад харилцааны төв архив, Ф№70, Х/Н№38, БНМАУ, ХБНГУ-ын улс төрийн харилцаа (1990-И/14-нөөс 1991-И/11)
- <sup>6</sup> 1991-VI сард Гадаад явдлын сайд Г.Гомбосүрэн, 1992-II сард Ерөнхий сайд Д.Бямбасүрэн ХБНГУ-д айлчилсан.
- <sup>7</sup> 1991-VII сард Төрийн сайд Х.Шэфер, 1992-VIII сард Холбооны Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн сайд К.Д.Шпрангер Монгол Улсад айлчилсан.
- <sup>8</sup> Монгол Улсын Гадаад харилцааны төв архив, Ф№70, Х/Н№50, Монгол-Германы улс төрийн харилцаа 1992 он
- <sup>9</sup> БНМАУ-ын Гадаад харилцааны төв архив, Ф№70, Х/Н№38, БНМАУ, ХБНГУ-ын улс төрийн харилцаа (1990-И/14-нөөс 1991-И/11)
- <sup>10</sup> БНМАУ-ын Гадаад харилцааны төв архив, Ф№70, Х/Н№50, Монгол-Германы улс төрийн харилцаа 1992 он
- <sup>11</sup> БНМАУ-ын Гадаад харилцааны төв архив, Ф№70, Х/Н№49, БНМАУ, аж-ын улс төрийн харилцаа 1991 он
- <sup>12</sup> Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (30.06.1994)-д стратегийн ач холбогдолтой үйлдвэрлэлийн салбарт хүнс, хөдөө аж ахуй, уул уурхайн аж үйлдвэр, хөнгөн аж үйлдвэр, химийн аж үйлдвэр тус тус оруулсан байна
- <sup>13</sup> Alexander Rahr, Ukraine, Kaukasus und Zentralasien: Wie die Europäer das "Great Game" verschlafen, In: KAS/Auslandsinformationen, 8/05, Politik, Juli 2003, S. 4

- 14 Verteidigungspolitische Richtlinien für den Geschäftsbereich des Bundesministers der Verteidigung vom 26. November 1992 (Wortlaut), In: Blätter für deutsche und internationale Politik, №9'93, S.1139
- 15 Mitteilung der Kommission, Die Beziehungen der Europäischen Union zu den neuen unabhängigen Staaten in Zentralasien, Kommission der Europäischen Gemeinschaften, Brüssel, den 10.10.1995, KOM (95)206. S.
- 16 Аюулгүй байдлын баталгаа-Клинтонд илгээлт явуулав, Үнэн сонин, 1993.11.15, №98 (18265), 1 дүгээр тал
- 17 НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 44 дүгээр чуулган дээр БНМАУ-ын Гадаад явдлын яамны сайд Ц.Гомбосүрэнгийн хэлсэн үг, Үнэн сонин, 1989.10. 07, №240 (17457), 6 дугаар тал
- 18 Холбооны Ерөнхийлөгчийн хэлсэн үг, Ардын эрх, 20.09.1995
- 19 Монгол Улсын гадаад харилцааны сайд Н.Туяа ХБНГУ-д ажлын айлчлал хийсэн тухай, Гадаад харилцаа товхимол (Монгол Улсын Гадаад харилцааны яамны мэдээллийн товхимол), №20 (70), 3 дугаар тал
- 20 Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, 1994
- 21 Leitlinien zur deutschen Asienpolitik, Botschafterkonferenz Asien-Pazifik, Nr. 9/S. 69, Bonn, den 28. Januar 1994
- 22 Aufgaben der deutschen Außenpolitik Ostasien am Beginn des 21. Jahrhunderts, Berlin, Mai 2002
- 23 А.Түвшинтөгс, Монгол Улс, ХБНГУ-ын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын төлөв; Монгол-Германы харилцаа: Өнгөрсөн үе-эдүгээ-хэтийн төлөв, 123 дугаар тал
- 24 Д.Галсандорж, Монгол, Германы худалдаа, хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал; Монгол-Германы харилцаа: Өнгөрсөн үе-эдүгээ-хэтийн төлөв, 98 дугаар тал
- 25 мөн тэнд, 99 дүгээр тал
- 26 <http://www.mongolia-foreign-policy.net/latestbig.php?id=187>
- 27 Германы уул уурхайн салбарынхан Монголыг сонирхов, Ардын эрх, 05.06.2006, 4 дүгээр тал
- 28 Ц.Даваадорж: Томоохон төслүүдийг олон улсын баг хэрэгжүүлнэ, Өнөөдөр, 02.10.2006, ЕЗ